



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/ҮС

Улаанбаатар хот

┌ Автотээврийн болон өөрөө явагч ┐
хэрэгслийн албан татвар, Агаарын бохирдлын
төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах талаар
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дэх хэсэг, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/96 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Дүүрэгт автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр (цаашид албан татвар, төлбөр гэх) хураах тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Дүүрэгт бүртгэлтэй бүх төрлийн тээврийн хэрэгслийн албан татвар, төлбөр хураах ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 03-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулж, орлогыг төсөвт төвлөрүүлэн, албан татвар, төлбөрөө төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дутуу төлөлтийг хураан барагдуулах, хариуцлага тооцох хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-д даалгасугай.

3. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтанд даалгасугай.

3.1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлд автотээврийн хэрэгслийн бүртгэл, төлбөрийн тогтолцоог шинэчлэн нэвтрүүлэх журам”-ын 3.4-т заасны дагуу автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, төлбөр хураах ажлыг зохион байгуулж, тухайн сардаа албан татвар, төлбөр төлөөгүй автотээврийн хэрэгсэлд хяналт тавьж, замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээ авч ажиллахыг Татварын хэлтэс (Х.Анхбаяр), Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Замын цагдаагийн хэсэг (Д.Билгээ)-д тус тус;

3.2. Албан татвар төлбөр төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хаягаар албан татвар, төлбөр төлөх мэдэгдэл хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Татварын хэлтэс (Х.Анхбаяр), Замын цагдаагийн хэсэг (Д.Билгээ), 1-р хорооны Засаг дарга (Н.Нямзав), 2-р хорооны Засаг дарга (Б.Батзориг)-т тус тус;

4. Албан татвар, төлбөр хураах ажлыг зохион байгуулж тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээ “smartcar.mn” систем, Татварын удирдлагын нэгдсэн систем “e-tax.mta.mn, i-tax.mta.mn” систем, “и-баримт” гар утасны аппликэйшн, гэрэгэ киоск төхөөрөмж ашиглан албан татвар, төлбөр төлөх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилж албан татвар, төлбөр төлөгчдөд үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлэн, дүүрэгт явуулын оношилогоо ирүүлэн аж ахуй нэгж, байгууллага болон иргэдийн бүх тээврийн хэрэгслийг хамруулан ажиллахыг ажлын хэсэг (Б.Болормаа)-д үүрэг болгосугай.


5. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах талаар авах зарим арга хэмжээний тухай” Дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/26 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 03 сарын 01 -ны өдрийн 1/28 дугаар
захирамжийн хавсралт



**АВТО ТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР,
АВТО ЗАМЫН ТӨЛБӨР, АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨР ХУРААХ АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга:	Б.Болормаа	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Х.Анхбаяр	Татварын хэлтсийн дарга
	Т.Лхагвасүрэн	Цагдаагийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа
Нарийн бичгийн дарга	Д.Билгээ	Замын цагдаагийн хэсгийн дарга цагдаагийн дэд хурандаа
	Н.Нямзав	1-р хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2-р хорооны Засаг дарга
	С.Бүрэнтөгс	Татварын улсын байцаагч